

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД БОЛОН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД
НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ
2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
(2024 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр)

2024 оны 11 дүгээр сарын 05

Улаанбаатар хот

Зорилт 6: Ойн нөөц ашиглалт, хамгаалалт, “Тэрбум” мод хөдөлгөөнийг өрнүүлэх зорилтын хэрэгжилтийг хангах хүрээнд:

Арга хэмжээ 6.6: “Жуулчин төгөл”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

Шалгуур үзүүлэлт: Тарьсан модны тоо

Суурь түвшин: 890


Зорилтот түвшин: 1000

Хэрэгжилт: “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “Цолмон трэйвел” ХХК, Монголын Аялал жуулчлалын холбоо хамтран Налайх дүүргийн “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнд “Жуулчин төгөл” байгуулах ажлыг 2022 онд эхлүүлж 18 төрлийн 610 мод, бут сөөг тарьж суулгасан.


“Ногоон хот-Иргэний оролцоо-2024” уриан дор зохион байгуулагдсан хаврын мод тарих арга хэмжээний хүрээнд “Жуулчин төгөл”-д тарьсан модны арчилгаа, цэнэг усалгаа нөхөн тарилтыг хийх, шинээр мод тарих ажлыг 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж 180 мод тарьж, мөн дэлхийн аялал жуулчлалын өдөр, Монгол Улсад аялал жуулчлалын салбар үүсэж хөгжсөний 70 жилийн ойг тохиолдуулан 2024 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр аялал жуулчлалын салбарын 30 гаруй байгууллагатай хамтран 10 төрлийн 326 мод, бут, сөөг тарих ажлыг зохион байгуулав.

Үндэсний хөдөлгөөний хүрээнд “Жуулчин төгөл”-д Монголын Аялал жуулчлалын холбоо, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо олон улсын байгууллага болон 70 гаруй тур оператор байгууллагатай хамтран нийт 27 төрлийн 1116 мод, бут сөөг тариад байна.

TOURIST TUGUL



TOURIST TUGUL





Зорилт 7: Аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд:

Арга хэмжээ 7.1: “Бүргэдийн баяр” арга хэмжээг хамтран зохион байгуулна.

Шалгуур үзүүлэлт: Арга хэмжээний хэрэгжилт, хувь

Суурь түвшин: Жил бүр зохион байгуулагддаг

Зорилтот түвшин: 100

Хэрэгжилт: “Монголд зочлох жил”-ийн хүрээнд Казах үндэстэн ястны ёс заншил, өв уламжлал, соёлыг сурталчлан таниулах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “Монголын бүргэдчид холбоо” ТББ, “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолбор хамтран 18 дахь жилдээ “Бүргэдийн баяр” арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 09,10-ны өдрүүдэд “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолборт зохион байгуулав.

Арга хэмжээнд Баян-Өлгий, Төв аймгуудаас 21 шилдэг бүргэдчинийг оролцуулан бүргэдтэй парад, бүргэдүүдийг танилцуулж алдаршуулах арга хэмжээ болон бүргэдчидийн дунд бүргэдээр шырга (хиймэл ан) бариулах тэмцээн, бүргэдээ хэрхэн сайн сургасан

байдлыг шалгаруулах тэмцээн, Казак үндэсний тоглоом көкбар (тулам булаалдах) тэмцээн, зоос шүүрэх тэмцээнүүдийг зохион байгууллаа.



Арга хэмжээний үеэр Үндэсний урлагийн их театр, Баян-Өлгий аймгийн Соёлын төвийн уран бүтээлчдийн тоглолт, “Морьтон баатруудын шоу тоглолт”, “Тайга анч нохдын үзүүлбэр”, шүхрийн үзүүлбэр болон тойром бүжиг, цаа буга, тэмээ, морь унах, бүргэд шувуу болон тэмээтэй зураг даруулах болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулж “Бүргэдийн баяр-2024” арга хэмжээг гадаад, дотоодын 25,000 гаруй хүн үзэж сонирхлоо.



Арга хэмжээ 7.2: “Дээлтэй Монгол наадам” арга хэмжээг хамтран зохион байгуулна.

Шалгуур үзүүлэлт: Арга хэмжээний хэрэгжилт, хувь

Суурь түвшин: Жил бүр зохион байгуулагддаг

Зорилтот түвшин: 100

Хэрэгжилт: Монголчуудын уламжлалт соёл, үндэстэн ястны дээл хувцас, эд хэрэглэл, ардын урлагийн биет болон биет бус өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Соёлын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын Аялал жуулчлалын холбоо, “Монгол Костюмс” ХХК хамтран “Дээлтэй Монгол наадам-2024” арга хэмжээг 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулав.

Баярын жагсаалд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймаг, Ордос аймаг, Баруун Үзэмчин хошуу, Шинжаан Уйгарын Өөртөө засах орны монголчууд, ОХУ-ын БНБуриад Улс, БНХалимаг Улс зэрэг бүс нутгаас 150 гаруй Монгол туургатны төлөөлөл, 21 аймаг, нийслэлийн 6 дүүрэг болон 18 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдээс 4826 хүн оролцлоо.



Оролцогчдоос шилдэг дүүрэг, шилдэг байгууллага, шилдэг дээл урлаач, гадаадын шилдэг эрэгтэй, эмэгтэй оролцогч, хамгийн сайхан дээлтэй хүүхэд зэрэг 12 номинациар

шилдгүүдийг тодруулж, арга хэмжээний үеэр урлагийн тоглолт, үндэсний хувцасны загварын шоу үзүүлбэр, дээлтэй диско зэрэг арга хэмжээ, 6 дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 138 иргэн, аж ахуй нэгж, байгууллага 40 асарт үндэсний дээл хувцас, эд хэрэглэлийн худалдаа үйлчилгээ зохион байгуулав. “Дээлтэй Монгол наадам-2024” арга хэмжээг гадаад, дотоодын 10,000 гаруй хүн үзэж сонирхсон.

Арга хэмжээ 7.3: “Хийморь” олон улсын морьт харвааны наадам арга хэмжээг хамтран зохион байгуулна.

Шалгуур үзүүлэлт: Арга хэмжээний хэрэгжилт, хувь

Суурь түвшин: Жил бүр зохион байгуулагддаг

Зорилтот түвшин: 100

Хэрэгжилт:Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, үндэсний соёл, уламжлалаар дамжуулан жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох зорилгоор “Хийморь” олон улсын морьт харвааны наадмыг Монголын морьт харвааны холбоотой хамтран 2024 оны 09 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөсөн ч арга хэмжээний төсөв батлагдаагүй улмаас цуцлагдсан.

Арга хэмжээ 7.4: Чингис хааны мэндэлсэн өдөр “Хаадын чуулбар” арга хэмжээг хамтран зохион байгуулна.

Шалгуур үзүүлэлт: Арга хэмжээний хэрэгжилт, хувь

Суурь түвшин: -

Зорилтот түвшин: 100

Хэрэгжилт: Чингис хааны мэндэлсэн өдөр буюу “Монгол бахархлын өдөр”-ийг тохиолдуулан Монголын түүх соёл, ёс заншлыг дэлхий дахинд сурталчлан таниулах, жуулчдыг татах шинэ бүтээгдэхүүн бий болгох зорилгоор “Хаадын чуулбар” арга хэмжээг 2024 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөсөн ч арга хэмжээний төсөв батлагдаагүй улмаас цуцлагдсан.

Арга хэмжээ 7.5: Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, арга хэмжээг хамтран зохион байгуулна.

Шалгуур үзүүлэлт: Оролцох арга хэмжээ, тоо

Суурь түвшин: 6 арга хэмжээнд оролцсон.

Хэрэгжилт: “Монголд зочлох жил”-ийн хүрээнд Монгол Улс, Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, тур оператор компаниудтай хамтран 3 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож, 5 арга хэмжээ, үзэсгэлэнг хамтран зохион байгууллаа.

Үүнд: ХБНГУ-ын Берлин хотноо 2024 оны 03 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан 58 дахь удаагийн “ITB BERLIN-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, БНСУ-ын Сөүл хотноо 2024 оны 05 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан 39 дахь удаагийн “SEOUL INTERNATIOL TRAVEL FAIR- 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, Япон улсын Токио хотноо 2024 оны 09 сарын 26-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “TRAVEL EXPO JAPAN-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцлоо.

БНХАУ-ын Гуан-жоу, Хонконг, Бээжин хотуудад “GO MONGOLIA-ROAD SHOW 2024” арга хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд, “Улаанбаатар травел экспо-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг 2024 оны 05 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд, “ITM Монголиа-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг 2024 оны 10 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд хамтран зохион байгууллаа.

“SEOUL INTERNATIOL TRAVEL FAIR- 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол улс “GO MONGOLIA” аялал жуулчлалын брэндийгээ сурталчлан

танилцуулж “Шилдэг PR маркетингтай” оролцогчоор, “ITM Монголиа-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Нийслэлийн Аялал жуулчлалын газраас Улаанбаатах хотын аяллыг танилцуулан “Шилдэг тохижилттой” оролцогчоор шалгарлаа.

“ITB Berlin 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн




“SEOUL INTERNATIOL TRAVEL FAIR- 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн






“Travel Expo Japan- 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн



“GO MONGOLIA” ROAD SHOW-2024




“Улаанбаатар трaвeл экспo-2024” oлoн улсын aялaл жуулчлaлын үзэсгэлэн





“ITM Монголиа-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн






Арга хэмжээ 7.6: Чингис хаан нисэх онгоцны буудал дээр “Жуулчны мэдээллийн төв”-ийг ажиллуулна.

Шалгуур үзүүлэлт: Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь

Суурь түвшин: -

Зорилтот түвшин: 100

Хэрэгжилт: Гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудалд байрлах “Жуулчны мэдээлэл сурталчилгааны төв”-ийг ажиллуулж 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн байдлаар 3677 жуулчинд мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.



Арга хэмжээ 7.7: Жуулчны лавлах (118) тусгай дугаарыг хамтран ажиллуулна.

Шалгуур үзүүлэлт: Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь

Суурь түвшин: -

Зорилтот түвшин: 100

Хэрэгжилт: Жуулчдын санал, хүсэлтийг хүлээн авах, зөвлөгөө, мэдээ мэдээллээр хангах лавлах 118 тусгай дугаарын утсыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 07 дугаар сарын 01-ний өдрийн хооронд ажиллуулан 11000 гаруй дуудлага хүлээн авч, 1600 гаруй гадаад, дотоодын иргэд, жуулчдад шаардлагатай мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.

Арга хэмжээ 7.8: Аялал жуулчлал, үйлчилгээний байгууллагын нэгдсэн бүртгэлийг хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлнэ.

Шалгуур үзүүлэлт: Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь

Суурь түвшин: -

Зорилтот түвшин: 100

Хэрэгжилт: Үйлчилгээ эрхлэх бүртгэл-Онлайн бизнес төв” цахим системд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг 111 амралтын газар, жуулчны бааз, 485 зочид буудал, 161 дэн буудал нийт 757 аялал жуулчлалын байр сууцны үйлчилгээний байгууллагын бүртгэлийг үүсгэн мэдээллийн сан бүрдүүлсэн.

Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдэд аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, бүтээгдэхүүн, үйлчилгээ, хот орчмын түүх соёлын дурсгалт газрууд, үзвэр үйлчилгээний газрууд, хотын аялал зэрэг бүлгүүдээр төрөлжүүлэн мэдээллийн сан үүсгэж тогтмол шинэчлэн гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллаж байна.

Арга хэмжээ 7.9: Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд хамтран ажиллана.

Шалгуур үзүүлэлт: Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь

Суурь түвшин: -

Зорилтот түвшин: 100

Хэрэгжилт: Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 458 дугаар тогтоолын хүрээнд Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах, өвлийн аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран “Мазаалай” олон улсын цас мөсний наадам, “Улаанбаатарын өвлийн наадам”, “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”, “Бүргэдийн баяр” зэрэг 4 арга хэмжээг зохион байгуулж гадаад, дотоодын нийт 127,600 гаруй хүн үзэж сонирхлоо.

“Мазаалай” олон улсын цас мөсний наадам





“Улаанбаатарын өвлийн наадам”



“Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”





“Бүргэдийн баяр”



Мөн өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор www.tourism.ub.gov.mn цахим хуудсаар дамжуулан “Өвлийн

улирлын хямдрал” цэс аяныг зохион байгуулж Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 9 салбарын 62 аж ахуйн нэгж, байгууллага 500 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээндээ 1+1 урамшуулал болон 10-50 хувь хүртэл хөнгөлөлттэй үйлчилгээг иргэд, жуулчдад үзүүлсэн.

“Өвлийн улирлын хямдрал” аян




ТАНИЛЦСАН:
ДАРГА




Д.БАТСҮХ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА



Д.ГАНБОЛД

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
БОДЛОГЫН БАРИМТ/БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН



О.НЯМБАТ